БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

ЗАВХАН АЙМГИЙН ТӨВД ШИНЭЭР БАРИГДАХ 21-Р ЗУУН 800 АЙЛЫН ЖИШИГ ХОРООЛЛЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2021.03.23 Дугаар: 2021/Ц-20 Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	1.1	Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 12-р сарын 28-ны өдрийн 6/1402 тоот албан бичиг,
	1.2	Эрчим хүчний яамны 2021 оны 03-р сарын 12-ны өдрийн 22/2021/252 тоот техникийн нөхцөл,
2. Байршил	2.1	Завхан аймаг, Улиастай сум, Өлзийт баг
3. Обьектийн бүрэлдэхүүн, хүч чадал	3.1	"21-р зуун 800 айлын жишиг хороолол"-ын цахилгаан хангамж,
	3.2	Улиастай сумын Өлзийт багийн 110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж/ХБ/-ийг ижил төрлийн ячейкаар өргөтгөн, хос кабель шугам /ЦДКШ/ татаж, шинээр баригдах 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж /РП/-ийг тэжээх,
		110/35/10 кВ-ийн "Улиастай" дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж /ХБ/:
	3.3	10 кВ-ын ХБ-д шинээр суурилуулах ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартуудын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалт сонгож суурилуулах, /нумын хамгаалалт/ тавилыг тохируулан, тавьж зүгшрүүлэлт тохиргоог хийж бүрэн ажиллагаанд оруулах,
	3.4	110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын ачаалал нэмэгдэж байгаа тул 110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын реле хамгаалалт автоматикуудын тавил тооцоог хийж, "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх,
	3.5	110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын 10 кВ-ын ХБ-аас 3*240 мм2 хөндлөн огтлол бүхий хос кабель шугам татаж, "21-р зуун" 800 айлын жишиг хороллын хаалттай хуваарилах байгууламжийг цахилгаан эрчим хүчээр хангах,
	3.6	ЦДКШ-ын трассыг зураг төслийн шатанд орон нутгийн болон ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох,
		Шинээр баригдах 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж /РП/:

3.7 Шинээр баригдах 10 кВ-ын ХБ-уудын I ба II секцийн ерөнхий шин нь бүрээстэй, байнгын газардуулгын хутгатай, өргөтгөн шинэчлэх боломжтой байх, зарчмын схемийг ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх,

3.8 ХБ-ийн 10 кВ-ын оруулгууд ба гаргалгуудыг вакуум таслуурууд, секц холбогч вакуум таслуур, секц холбогч салгуур, дотоод хэрэгцээний болон хүчдэлийн трансформаторууд тусдаа ячейкууд байх,

3.9 10 кВ-ын ХБ-д шинээр суурилуулах ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартуудын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалт сонгож суурилуулах, /нумын хамгаалалт/ тавилыг тохируулан, тавьж зүгшрүүлэлт тохиргоог хийж бүрэн ажиллагаанд оруулах,

3.10 Шинээр суурилагдах ячейк нь халаагуурын систем, температурын датчик, кабелийн холболтын камерт нумын хамгаалалт, газардуулгын дохиолол, фазын дараалын индикатор зэргээр тоноглогдсон байх,

3.11 Шинээр суурилуулах ячейкуудад хэрэглэгчийн ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалттай гүйдлийн трансформатор, кабелийн үзүүрт тооцооны үндсэн дээр хэт хүчдэл хязгаарлагч /ОПН/ сонгох, ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх,

3.12 10 кВ-ын ХБ-ийн бүх ячейкийг сүүлийн үеийн олон улсын стандартын шаардлага хангасан компьютерийн удирдлага хяналтын системээр хянадаг, вакуум таслуур бүхий иж бүрэн ячейкуудыг суурилуулж, хэмжилт туршилт хийж бүрэн ажиллагаанд оруулах;

3.13 10 кВ-ын ХБ-ийн оролт болон гаргалгааны 10 кВ, 0,4 кВ-ын хүчний кабель шугам /ЦДКШ/ нь MNS 6519:2015 стандартын шаардлагыг хангасан байх,

3.14 ХБ-ийн 10 кВ, 0,4 кВ-ын кабелийн туннель, тоноглолд засвар үйлчилгээ хийх зай талбайг норм дүрмийн шаардлагад нийцсэн байхаар зураг төсөлд тусгах, ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх,

3.15 Хуваарилах байгууламжийн барилга нь тоосгоор баригдсан байх шаардлагатай бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар барих,

3.16 "21-р зуун" 800 айлын жишиг хороллын гадна цахилгаан хангамжинд 10 кВ-ийн 3*240 мм2 хөндлөн огтлол бүхий хос кабель шугам татаж 10/0,4 кВ-ын 2*400 кВА чадалтай /ХТП/ дэд станцуудыг барих,

3.17 Шинээр баригдах 10/0,4 кВ-ын дэд станц нь MNS 6520:2015 стандартын шаардлагыг хангасан байх ба дэд станцын тоо болон хүчин чадлыг хэрэглээтэй нь уялдуулан тооцоогоор сонгох, ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх,

3.18 Дэд станцад шинээр суурилуулах 10/0.4 кВ-ын хүчний трансформаторууд нь олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагуудыг хангасан байх,

3.19 Дэд станцын газардуулгыг норм дүрмийн дагуу зураг төсөлд тусгах,

3.20 Олон Улсын IEC 62056 цуврал стандартын шаардлагыг хангасан, Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий, ашиглагч байгууллагын техникийн шаардлагын хангасан тоолуур сонгох,

3.21 Шинээр баригдах барилга байгууламж нь барилгын норм дүрмийг хангасан, зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх,

3.22 Тооцоогоор сонгогдсон тоног төхөөрөмжүүд нь Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх,

3.23 Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах,

3.24 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх,

3.25 Реле хамгаалалтын тавил тооцоог эрх бүхий байгууллагаар хийлгэж "Диспетчерийн үндэсний төв" ХХК болон ашиглагч "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх,

3.26 Ачаалалд нь тохирсон коэффициент бүхий Олон улсын IEC 62056 стандартын шаардлагыг хангасан хэмжих хэрэгсэл суурилуулах, Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий ашиглагч байгууллагын техникийн шаардлагын дагуу тоолуур сонгох ба тоолуурын системд холбосон зураг төсөл боловсруулах,

3.27 Техникийн нөхцөлд дурдсан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах,

4. Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага

4.1 Дэд станцад шинээр суурилагдах тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний 1000 м-ээс дээш өндөрлөг, олон улсын IEC стандарт, техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байх бөгөөд өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, ±10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

4.2 RS 485 интерфейсийн шаардлага хангасан IEC-61107, IEC-60256 холболтын протоколтой, Монгол улсын стандартчилал хэмжил зүйн газраар баталгаажиж ашиглахыг зөвшөөрсөн, Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан, санах ой бүхий 0,2 нарийвчлалтай, ухаалаг тоолуур, ачаалалд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор, хэт хүчдэл хязгаарлагч сонгох,

4.3 Цахилгаан дамжуулах кабель шугамын суваг, үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас, угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газар нутгийн байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан сонгох,

5.	Инженерийн хангамж	Техникийн нөхцөлд дурдсан инженерийн хангамж,
6.	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Нэг үе шаттай, техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд
7.	Цаашид өргөтгөх эсэх	Цаашид өргөтгөх боломжтойгоор зай талбайг тооцож зураг төсөлд тусгах,
8.	Барих хугацаа	2021- 2022 он
9.	Гүйцэтгэгч байгууллага	"Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл" авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх,
10.	Захиалагч байгууллага	Завхан аймгийн ЗДТГ, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК
11.	Зургийн байгууллага	"Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл" авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх
12.	Онцгой нөхцөл	12.1. Зураг төслийг Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн мехник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн заалтын дагуу гүйцэтгэх. 12.2. Зураг төслийг улсын экспертизэд оруулахын өмнө ашиглагч- байгууллага "АУЭХС" ТӨХК болон Онцгой байдлын ерөхний газар бусад холбогдох газруудаар хянуулж, зөвшөөрөл авсан байх. 12.3. Болзошгүй аваар саатал, гэмтлийн үед, шаардлагатай цахилгаан эрчим хүчний ачаалалд тохирсон аваарийн нөөц тэжээлийг шийдвэрлэх. 12.4. Хүчний болон гэрэлтүүлгийн самбарт давтан газардуулга, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах.

БОЛОВСРУУЛСАН:
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Н.МӨНХБАТ